

# 11.0. Ойлголт

Энэхүү модулийн зорилго нь дипломын дугаарын захиалга, хувиарлалт хийх үйл ажиллагааг удирдах юм. ДБУМС-д төгсөх оюутнуудын дипломын захиалга шинээр үүсгэх, засах, цуцлах, дипломын дугаар хуваарилах, захиалга шийдвэрлэх, дипломын дугаар буцаан татах, төгсөгчдийн лавлагаа үүсгэх үйлдлүүдийг хийж удирдах явдал юм. БШУЯ, түүний харьяа байгууллага, сургууль өөрийн эрх үүргийн хүрээнд төгсөлтийн холбогдох мэдээллийг харах, хянах ба улсын хэмжээний дээд боловсролын төгсөгчдийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, real, статистик, аналитик тайлан гаргах боломжтой.



**Байгууллага нэгтгэл**  
Сургалтын байгууллага, салбар бүрэлдэхүүн сургууль



**Зөвлөл, хороо нэгтгэл**  
Удирдах зөвлөл, эрдмийн зөвлөл, комисс, хороо



**Байгууллагын санхүү нэгтгэл**  
Байгууллагын орлого, зарлага, хөрөнгө



**Сургалтын орчин нэгтгэл**  
Хичээлийн байр, дотуур байр, номын сан, анги танхим, өрөө, хэрэглэгдэхүүн



**Тусгай зөвшөөрөл нэгтгэл**  
Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл, нөхцөл шаардлага



**Магадлан итгэмжлэл**  
Байгууллага, хөтөлбөрийн магадлан итгэмжлэл



**Хөтөлбөрийн нэгтгэл**  
Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө



**Сургалтын агуулга нэгтгэл**  
Хичээл, дадлага ба ажил, шалгалт



**Суралцагчийн нэгтгэл**  
Элсэлт, шилжилт хөдөлгөөн, суралцагчийн дэлгэрэнгүй мэдээлэл



**Дүн үнэлгээ нэгтгэл**  
Хичээл, дадлага ажил, шалгалтын дүн



**Дипломын дугаар, захиалга**  
Дипломын дугаар захиалга, дугаар шийдвэрлэлт



**Төгсөлт нэгтгэл**  
Төгсөлт, баримт бичиг олголт, баталгаажуулалт

## Дипломын дугаар захиалгын мэдээлэл

| №  | Талбар                  | Тайлбар                                                         | Жишээ                     |
|----|-------------------------|-----------------------------------------------------------------|---------------------------|
| 1  | Сургалтын байгууллага   | Сургалтын байгууллагын нэр                                      | МУБИС                     |
| 2  | Сургууль                | Салбар, бүрэлдэхүүн сургуулийн нэр                              | Боловсрол судлал сургууль |
| 3  | Захиалгын нэр           | Дипломын дугаарын захиалгын нэр бичнэ. Нэр нь давхцахгүй байна. | 2019 оны өвөл             |
| 4  | Захиалга илгээсэн огноо | Захиалга илгээсэн огноо                                         | 2019.02.01                |
| 5  | Боловсролын зэрэг       | Боловсролын зэрэг сонгоно.                                      | Бакалаврын зэрэг          |
| 6  | Хичээлийн жил           | Захиалга хийж буй хичээлийн жил сонгоно.                        | 2018-2019                 |
| 7  | Хичээлийн улирал        | Захиалга хийж буй улирал сонгоно.                               | 1-р семестр               |
| 8  | Захиалгын тоо           | Дипломын дугаар захиалж буй суралцагчийн тоо                    | 45                        |
| 9  | Зөвшөөрсөн суралцагч    | Захиалгыг зөвшөөрч дугаар хуваарилах суралцагчийн тоо           | 30                        |
| 10 | Татгалзсан суралцагч    | Захиалга цуцлагдсан                                             | 15                        |

|    |                    |                                              |                  |
|----|--------------------|----------------------------------------------|------------------|
|    |                    | суралцагчийн тоо                             |                  |
| 11 | Хуваарилсан дугаар | Захиалга шийдвэрлэн хуваарилсан дугаарын тоо | 20               |
| 12 | Захиалгын төлөв    | Захиалгын төлөв харуулна.                    | Хүлээгдэж байгаа |